



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
САЛБАРЫН УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 07/00-00/001-04

Улаанбаатар хот

Зам, тээврийн салбарт хөдөлмөрийн
аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж
ажиллах тухай

Зам, тээврийн салбарт ажиллагсад албан үүргээ гүйцэтгэх болон албан томилолт, ажлын байр, нэгж хэсгийн хооронд тээврийн хэрэгслээр зорчих явцдаа үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртөж, улмаар амь насаа алдах тохиолдлууд цөөнгүй гарч байна.

Сүүлийн 5 жилд зам, тээврийн салбарт нийт 174 үйлдвэрлэлийн осол бүртгэгдэж, 60 хүн хөнгөн, 95 хүн хүнд гэмтэж, үйлдвэрлэлийн ослын улмаас 19 хүн нас барсан тохиолдол бүртгэгдсэн байна. Зам, тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүйгээс ажилтан, зорчигчдын амь нас, эрүүл мэнд хохирч байна.

Иймд зам, тээврийн салбарт гарч болзошгүй үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлж, ажилтны болон зорчигчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зам, тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч нарт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, журам, стандартын дараах шаардлагыг ханган ажиллахыг ДААЛГАЖ байна.

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомж, үндэсний стандарт, түүнтэй холбогдуулан гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг мөрдөж ажиллах;

2. Аж ахуйн нэгж, байгууллага бүр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн алба, орон тооны хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан, хөдөлмөрийн эрүүл ахуйчийг хууль тогтоомжид заасан бүтэц орон тоогоор ажиллуулах;

3. Зам, тээврийн салбарын аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын бүх түвшинд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хүлээх үүрэг хариуцлагын тогтолцоог тодорхой болгож, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд тусгаж хэрэгжүүлэх;

4. Ажлын байранд ажиллагсад албан үүргээ гүйцэтгэх явцад тохиолдож болох аюулыг тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах эрсдэлийн үнэлгээг хийж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг ханган ажиллах төлөвлөгөө боловсруулан баталж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай хөрөнгө, зардлыг төсөвлөн, зарцуулалтад хяналт тавих;

5. Ажлын байрны онцлогт тохирсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын төлөвлөгөө боловсруулж, нийт ажиллагсдыг жилд хоёроос доошгүй удаа, мөн эрсдэлтэй ажлын байранд ажил үүрэг гүйцэтгэдэг ажиллагсдыг тусгай (химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэдэг) сургалтад

1511180027

хамруулж, өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, чадвар, дадлагыг ажилтан бүрт эзэмшүүлж, шалгалт өгч, зааварчилгаа авсан ажиллагсдыг ажлын байранд ажиллуулах;

6. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажиллагсдыг тогтмол хамруулах;

7. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон стандартын шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр хангаж, хэрэглэж хэвшүүлэхэд хяналт тавих;

8. Эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажиллагсдыг амь нас, эрүүл мэндийн даатгалд тухайн ажилтны 36 ба түүнээс дээш сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээгээр заавал даатгуулж, хураамжийг ажил олгогч хариуцах;

9. Ажиллагсдыг байнга оршин суудаг газраас нь алслагдсан газар байрлуулж ажил үүрэг гүйцэтгүүлж байгаа ажил олгогч нь ажлын ээлж эхлэх болон дуусах үед тодорхой тогтоосон байрлал бүхий газраас ажлын байр, амрах байранд хүргэх болон гэрт нь буцаахдаа даатгагдсан баталгаат тээврийн хэрэгслээр зорчих зохицуулалтыг хийхээр журамлах;

10. Нүүрс тээврийн жолооч нар нь машины кабинд болон амрах байрандаа цус харвалт, зүрхний шигдээс гэсэн оношоор нас барах тохиолдол нэмэгдэж байгаатай холбогдуулан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар онцгой анхаарч ажиллах;

11. Уурхайгаас нүүрс ачих болон Хятад улсын хилийн боомтод нүүрс гаргахаар хүлээж байгаа нүүрс тээвэрлэдэг машины жолооч нарын ажил, амралтын цагийг хуулийн дагуу зөв зохицуулж, тээврийн жолооч нарт дулаацах, амрах, хооллох зориулалтаар тоноглож тохижуулсан ахуйн байраар хангах асуудлыг нүүрсний уурхай, нүүрс тээврийн компанийн хооронд хийгдсэн ажил гүйцэтгэх гэрээнд тусгаж, хэрэгжүүлэх;

12. Зам болон замын барилга, байгууламжийн ажлыг гүйцэтгэхдээ "Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн /БНБД 12-03-04/-ийн 6.4.2 /Үйлдвэрлэлийн талбайд цахилгааны байнгын ба түр сүлжээний техникийн үйлчилгээг, цахилгааны аюулгүй ажиллагааны зохих мэргэжлийн зэрэг бүхий цахилгаан техникийн ажилтнуудаар гүйцэтгэвэл зохино/-т заасныг баримтлан цахилгааны аюулгүй байдлыг хангаж ажиллаж байгаа эсэх, цахилгааны түр щит, гал хамгаалагчийн бүрэн бүтэн байдал, цоожлох пайзлах журам баталж мөрдүүлэх;

13. Үйлдвэрлэлийн орчинд ашиглагдаж байгаа өргөх, зөөх, тээвэрлэх машин механизм, тоног төхөөрөмж, цахилгааны болон даралтат сав, химийн хортой болон аюултай бодисын аюулгүй байдлыг хангуулан, аюулгүй ажиллагааны заавар, дохио санамж тэмдэг, тэмдэглэгээг байрлуулж, гал унтраах дүрэм, журмыг мөрдөж, галын аюулаас урьдчилан сэргийлж, ажиллах;

14. Хүний амь нас, эрүүл мэндэд шууд ба шууд бусаар хор хохирол учруулж байгаа болон учруулж болзошгүй үйл ажиллагааг шууд зогсоож, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилган, осол, хурц хордлогын улмаас гэмтсэн, нас барсан ажилтны осол гэмтэл, хурц хордлогод өртсөн шалтгаан, хүчин зүйлийг Засгийн газраас тогтоосон дүрмийн дагуу судлан тогтоож, холбогдох байгууллагуудад хүргүүлэх, цаашид осол гаргуулахгүй байх талаар арга хэмжээг төлөвлөж ажиллах;

15. Ажиллагсдад зориулсан ахуйн байрыг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулах, эрүүл ахуйн шинжилгээтэй, илчлэг сайтай хоол хүнс, ундны усаар хангаж, тогтмол хяналт тавих;

16. Ажиллагсдын ажил амралтын цаг, цалин нэмэгдлийн асуудлыг хуульд нийцүүлэх, үйлдвэрлэлийн орчин, засвар үйлчилгээний талбайн аюулгүй байдал, авто замын тоосжилтыг бууруулах, замын орц, гарц, тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах, замын усалгааг хийх, зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх;

17. Туслан гүйцэтгэгчээр ажиллаж байгаа компаниудын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаар захиалагч компанийн зүгээс хяналт тавих, зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулах, шаардлагатай тохиолдолд хариуцлага тооцох арга хэмжээ авч ажиллах;

18. Ажлын байранд хийсэн эрсдэлийн үнэлгээний дагуу хийгдсэн арга хэмжээний биелэлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, стандартын шаардлагын хэрэгжилтэд дотоод хяналт шалгалтыг тогтмол хийж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх;

Албан даалгаврыг зам, тээврийн салбарын аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч бүр хэрэгжүүлэн, биелэлтийг үйл ажиллагаа эрхэлж буй нутаг дэвсгэрт хамаарах аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 2024 оны 10 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэн, орон нутгийн зөвлөл нь албан даалгаврын биелэлтийг зөвлөлийн хурлаар хэлэлцэн, цаашид хэрэгжүүлэх зөвлөмж, шийдвэр гаргаж ажиллахыг даалгаж байна.

САЛБАРЫН УЛСЫН ЕРӨНХИЙ
БАЙЦААГЧ



Б.НАРАНГАРАВ

Боловсруулсан:
Хянасан:
Хүрэг: